



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/143

Улаанбаатар хот

Нислэгийн аюулгүй ажиллагааг
сайжруулах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Тушаал хүчингүй болгох тухай” А/56 дугаартай тушаалыг хүчингүй болгосугай.

2. “Зорчигч тээврийн агаарын хөлгийн насжилт 20 жилээс дээшгүй байх”, “Нисгэгчийн үнэмлэх болон зэрэглэл эзэмшигчийн насны хязгаарлалт 60 наснаас дээшгүй байх” заалтыг холбогдох иргэний нисэхийн дүрэмд нэмэлт өөрчлөлтөөр оруулах ажлыг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулан ажиллахыг Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газар (П.Ариунболд), Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба (П.Ганболд)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Иргэний нисэхийн дүрмийн нэмэлт, өөрчлөлт батлагдах хүртэл 20 жилээс дээш насжилттай зорчигч тээврийн агаарын хөлөгт тавих нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, 60-аас дээш настай нисгэгчийн үнэмлэх болон зэрэглэл эзэмшигчдэд тавих хяналтыг тогтмол гүйцэтгэж ажиллахыг Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба (П.Ганболд)-нд даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Нислэгийн аюулгүй ажиллагааг сайжруулах зарим арга хэмжээний тухай А/126 дугаартай тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН